

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЖИЛИЙН ТАЙЛАН  
2025 ОН

# АГУУЛГА

---

ӨМНӨХ ҮГ	06
ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ	08
НЭГ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ	13
ХОЁР. ХУУЛЬ, ТОГТООМЖ	19
ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	25
ДӨРӨВ. БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ	41
ТАВ. БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ	59
ЗУРГАА. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТЭМЦЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ	67
ДОЛОО. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУДАЛГАА, КОМПЛАЙНС, САНХҮҮ	73

## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<b>Зураг 1.</b>	Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт	15
<b>Зураг 2.</b>	Санхүүгийн салбарын зохицуулалттай этгээдүүд	29
<b>Зураг 3.</b>	Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд	31
<b>Зураг 4.</b>	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	32
<b>Зураг 5.</b>	Нийт арилжааны дүн	32
<b>Зураг 6.</b>	УУББ–ийн арилжааны дүн	32
<b>Зураг 7.</b>	Арилжааны дүн /тэрбум төгрөг/	32
<b>Зураг 8.</b>	Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан /тэрбум төгрөг/	33
<b>Зураг 9.</b>	Даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	33
<b>Зураг 10.</b>	Даатгалын хураамж /тэрбум төгрөг/	33
<b>Зураг 11.</b>	Өөрийн болон хөрөнгийн өгөөж /тэрбум төгрөг/	33
<b>Зураг 12.</b>	ББСБ–ын нийт хөрөнгө / тэрбум төгрөг	34
<b>Зураг 13.</b>	ББСБ–ын зээлийн ангилал /их наяд төгрөг/	34
<b>Зураг 14.</b>	ББСБ–ын чанаргүй зээл ба ЗЖДХ / тэрбум төгрөг/	34
<b>Зураг 15.</b>	ББСБ–ын нийт орлого, нийт зарлага /тэрбум төгрөг/	34
<b>Зураг 16.</b>	ХЗХ–ны нийт хөрөнгө	35
<b>Зураг 17.</b>	ХЗХ–ны зээл	35
<b>Зураг 18.</b>	ХЗХ–ны хөрвөх чадвар	35
<b>Зураг 19.</b>	ХЗХ–ны зээл болон хадгаламжийн жигнэсэн дундаж хүү	35
<b>Зураг 20.</b>	Нийт хөрөнгө ба зээл /тэрбум төгрөг/	36
<b>Зураг 21.</b>	Үл хөдлөх хөрөнгийн худалдаа	36
<b>Зураг 22.</b>	Үл хөдлөх хөрөнгийн түрээс	36
<b>Зураг 23.</b>	Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	37
<b>Зураг 24.</b>	Олон улсын болон дотоодын ногоон, нийгмийн тогтвортой бондын эзлэх хэмжээ	38
<b>Зураг 25.</b>	Дотоодын бондын төрөл	38
<b>Зураг 26.</b>	Дотоодын ногоон бондын татан төвлөрүүлсэн дүн	38
<b>Зураг 27.</b>	Биржийн болон биржийн бус зах зээлд арилжаасан дүн	38
<b>Зураг 28.</b>	Ногоон зээлийн үлдэгдэл	39
<b>Зураг 29.</b>	Газар дээрх бүрэн хэмжээний, хэсэгчилсэн хяналт шалгалт болон үзлэг шалгалтын тоо салбараар	68
<b>Хүснэгт 1.</b>	Үйл ажиллагаанд дагаж мөрддөг хуулиуд	20
<b>Хүснэгт 2.</b>	Авсан арга хэмжээнүүд	21
<b>Хүснэгт 3.</b>	Хэрэгжилт	22
<b>Хүснэгт 4.</b>	Зохицуулалтын салбарын ажилчдад зориулж зохион байгуулсан сургалтууд	55

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>АНДМУТБ</b>	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
<b>АНУ</b>	Америкийн Нэгдсэн Улс
<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>ББСБ</b>	Банк бус санхүүгийн байгууллага
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>БОНЗ</b>	Байгаль орчин, нийгэм, засаглал
<b>ВХҮҮ</b>	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
<b>ГВУН</b>	Гадаад валютын улсын нөөц
<b>ГҮТББ</b>	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЭГДҮЦ</b>	Засгийн газрын дотоод үнэт цаас
<b>ЭГХЭГ</b>	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ЗЖДХ</b>	Зээлийн жигнэсэн дундаж хүү
<b>МАБ</b>	Мэдээллийн аюулгүй байдал
<b>МЗҮА</b>	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа
<b>МЗҮАЭ</b>	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч
<b>МУ</b>	Монгол Улс
<b>МУИС</b>	Монгол Улсын Их Сургууль
<b>МУТСТ</b>	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
<b>МУТА</b>	Мөнгө угаахтай тэмцэх алба
<b>МҮХАҮТ</b>	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
<b>МҮЦКТ</b>	Монголын үнэт цаасны клирингийн төв
<b>МҮЭ</b>	Мэдээлэх үүрэгтэй этгээд
<b>МХЗХҮХ</b>	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>ОУСК</b>	Олон Улсын Санхүүгийн Корпораци
<b>ОХУ</b>	Оросын Холбооны Улс
<b>СЭЗИС</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
<b>СЗХ</b>	Санхүүгийн зохицуулах хороо
<b>ТУЗ</b>	Төлөөлөн удирдах зөвлөл
<b>ТТАХНЭ</b>	Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>УУББ</b>	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж
<b>ҮМҮЧЭТХЭАЭ</b>	Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
<b>ҮХЭХЗ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
<b>ҮХЭХЗБ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө зуучллын байгууллага
<b>ҮЦЗЗ</b>	Үнэт цаасны зах зээл
<b>ҮЦТХТ</b>	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

---

<b>ФАТФ</b>	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
<b>ХБУЦ</b>	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
<b>ХЗДХЯ</b>	Хууль зүй, дотоод хэргийн яам
<b>ХЗЗ</b>	Хөрөнгийн зах зээл
<b>ХЗХ</b>	Хадгаламж, зээлийн хоршоо
<b>ХК</b>	Хувьцаат компани
<b>ХНХ</b>	Хувь нийлүүлсэн хөрөнгө
<b>ХОМК</b>	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
<b>ХОС</b>	Хөрөнгө оруулалтын сан
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ЦЕГ</b>	Цагдаагийн ерөнхий газар
<b>ШШГЕГ</b>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
<b>ЭЗБТХ</b>	Эрх зүйн байдлын тухай хууль
<b>ЭЗБХ</b>	Эдийн засгийн байнгын хороо
<b>2FA</b>	Two-Factor Authentication
<b>AFI</b>	Alliance for Financial Inclusion
<b>AML</b>	Office – Anti-Money Laundering Office
<b>API</b>	Application Programming Interface
<b>APRC</b>	Asia Pacific Research Committee
<b>AUSTRAC</b>	Australian Transaction Reports and Analysis Centre
<b>B2B</b>	Business to Business
<b>FCA</b>	Financial Conduct Authority
<b>FINCEN</b>	Financial Crimes Enforcement Network
<b>FINTRAC</b>	Financial Transactions and Reports Analysis Centre of Canada
<b>FMA</b>	Financial Markets Authority
<b>FRC</b>	Financial Regulatory Commission
<b>FSA</b>	Financial Services Agency
<b>GEMC</b>	Global Energy Metals Corporation
<b>IMF</b>	International Monetary Fund
<b>IOSCO</b>	International Organization of Securities Commissions
<b>IPO</b>	Initial Public Offering
<b>ISLA</b>	International Securities Lending Association
<b>KIDI</b>	Korea Insurance Development Institute
<b>MOF</b>	Ministry of Finance
<b>OTC</b>	Over-the-Counter
<b>P2P</b>	Peer-to-Peer
<b>SC</b>	Securities Commission
<b>SSL</b>	Secure Sockets Layer
<b>TNC</b>	The Nature Conservancy
<b>VACG</b>	Virtual Asset Contact Group

## ӨМНӨХ ҮГ



Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Та бүхэнд толилуулж байна.

2025 онд Монгол Улсын эдийн засаг 6.8 хувиар өсөж, Монгол Улсын зээлжих зэрэглэл ВВ-, тогтвортой төлөвт шилжин 2012 оноос хойших хамгийн өндөр түвшинд үнэлэгдлээ. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбаруудын хөрөнгө, зах зээлийн хэмжээ нэмэгдэж ДНБ-д харьцуулсан дүнгээр 26.8 хувьд тэнцэхүйц хэмжээнд хүрсэн нь улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хувьд өсөлт, хөгжлөөр баялаг жил байсныг илтгэнэ.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 онд олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг олон улсын жишигт

нийцүүлэн шинэчлэх, зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажиллалаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хувьцааны хамтын санхүүжилтийн үйлчилгээ, банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжих, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ, олон улсын санхүүгийн байгууллагуудын оролцоотой үнэт цаас гаргах зэрэг шинэ зохицуулалтыг бүрдүүлэв. Мөн “нийгмийн бонд”, “тогтвортой байдлын бонд” зэрэг тогтвортой санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлэх, урт хугацааны хөрөнгө оруулалтыг дэмжих чухал алхам боллоо. 2025 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 13.9 их наяд төгрөгт, үнэт цаасны арилжааны хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Даатгалын салбарт олон тулгуурт даатгалын тогтолцоог бүрдүүлэх, даатгагчийн баталгаа, ипотекийн даатгал, заавал даатгалын үйлчилгээг дэмжих, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд бодлого, зохицуулалтад өөрчлөлт оруулан ажиллалаа. Тухайлбал, Даатгалын багц дүрэмд өөрчлөлт оруулан дотоодын даатгалын компаниудын баталгааны дээд хэмжээг 4 дахин нэмэгдүүлэв. 2025 оны байдлаар нийт 611.8 тэрбум төгрөгийн даатгалын баталгаа гарсан байна. Мөн ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг урт хугацааны даатгалд төвлөрүүлэх зохицуулалт бүрдүүлээ.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж буй

хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах, иргэдийн өрийн дарамтыг бууруулах, хариуцлагатай зээл олголтыг төлөвшүүлэх зорилгоор макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Эдгээр бодлогын үр дүнд хэрэглээ болон автомашины зээлийн өсөлт саарч, бизнесийн зээлийн санхүүжилт нэмэгдэх эерэг өөрчлөлтүүд гарч байна. Түүнчлэн Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан нь тус салбарын эрх зүйн орчныг шинэ шатанд гаргах зорилготой юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь хууль тогтоомж, бодлогын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах, зах зээлийн оролцогчдын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ технологи, инновацид суурилсан, байгаль орчин, нийгмийн хариуцлагыг дэмжсэн тогтвортой санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Ирэх 2026 онд Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 20 жилийн ой тохионо. Өнгөрсөн 20 жилийн

хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 11 салбарын 5,930 зах зээлийн оролцогчийг зохицуулалтдаа хамруулсан, олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын эгнээнд зүй ёсоор нэгдсэн байгууллага болон хөгжиж байна. Анх зөвхөн үнэт цаас, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны салбарыг зохицуулж байсан бол өнөөдөр үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, цаашлаад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, уул уурхайн бүтээгдэхүүний бирж, финтекийн салбарыг хамрах болсон нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн шинэ чиг хандлагатай нийцсэн өөрчлөлт юм.

Цаашид бид зохицуулалтын салбарын эрх зүйн шинэчлэлийг хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мэргэжлийн, урт хугацааны хөрөнгө оруулагчдын суурийг бий болгох, урт хугацааны хуримтлал, хөрөнгө оруулалтын чадавх бүхий олон тулгуурт, ил тод, тогтвортой санхүүгийн системийг хөгжүүлэхэд бодлого, зохицуулалтаа чиглүүлэн ажиллах болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

# ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

# 1

**МЭРГЭЖЛИЙН  
ХӨРӨНГӨ  
ОРУУЛАГЧДАД  
ҮНЭТ ЦААС  
ЗЭЭЛДҮҮЛЭХ  
БОЛОМЖИЙГ  
НЭЭСЭН  
ЗОХИЦУУЛАЛТЫГ  
БАТАЛЛАА**



УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (International Securities Lending Association, ISLA)-ны зарчим болон олон улсын зохицуулалтын жишигт тулгуурлан “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-ыг баталснаар, хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчид өөрийн эзэмшлийн үнэт цаасаа зээлдүүлэх замаар нэмэлт орлого олох, хөрөнгө оруулалтын багцаа илүү үр ашигтайгаар удирдах боломжтой боллоо.

# 2


**МОНГОЛ УЛСЫН БИРЖИЙН БУС ЗАХ  
ЗЭЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА 24 ЦАГИЙН ГОРИМД  
ШИЛЖЛЭЭ**



“Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ГҮТББ-аас хэрэгжүүлсэн биржийн бус зах зээлийн блокчэйд суурилсан арилжааны платформ нь сэндбоксын зохицуулалтын орчинд амжилттай туршигдаж, зах зээлд бүрэн нэвтэрснээр арилжаа, төлбөр тооцоог 24/5 цагийн горимоор, ил тод, тасралтгүй гүйцэтгэх боломж бүрдэж, Монгол Улс биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн технологийг нэвтрүүлсэн анхдагч орны нэг боллоо.

# 3

## МОНГОЛ УЛСАД ХАМГИЙН АНХНЫ GOLD ETF ҮҮСГЭН БАЙГУУЛАГДЛАА



Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан /Gold ETF/-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэлээ. Тус сан нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хүрээнд хөрөнгийг боломжит санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар алтны үнийн хөдөлгөөнөөс өгөөж болон эрсдэлийг нэгж эрх эзэмшигчдэд хүртээхэд чиглэнэ.

# 4



## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БОНД ГАРГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны 116 дугаар тогтоолоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д олон улсын санхүүгийн байгууллагаас өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг тусган баталсан. Ингэснээр олон улсын санхүүгийн байгууллагаас дотоодын хөрөнгийн зах зээлд бонд гаргах боломж бүрдлээ.

# 5


## ӨР ОРЛОГО, ЗЭЭЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦАА ТОГТООЛОО



Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэд олон нийтийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагуудаас олгож буй хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд өр орлогын харьцаа болон автомашин барьцаалсан зээл-үнэлгээний харьцааг тус тус 60 хувиас хэтрэхгүй байхаар тогтоолоо.

# 6

## ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ДЭЭД ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ



Даатгалын багц дүрмийн 17 дугаар хавсралт журмыг шинэчлэн, 2, 3, 4, 10 дугаар хавсралт журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар дотоодын даатгалын компаниудын гаргах баталгааны дээд хэмжээ 4 дахин нэмэгдэх, улмаар даатгагчийн баталгаа нь зөвхөн төрийн худалдан авах ажиллагаанд хязгаарлагдах бус ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр, хувийн хэвшлийн худалдан авалт, ажил гүйцэтгэх гэрээнүүд зэрэг олон чиглэлд ашиглагдах боломжтой боллоо. Энэ нь аж ахуйн нэгжүүдийг бусад төрлийн даатгалд хамруулах, эрсдэлээ хамгаалах ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар даатгалын зах зээлийг бүхэлд нь тэлэх стратегийн ач холбогдолтой хөшүүрэг юм.

# 7

## ОРОН НУТГИЙН ХЭХ-ДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ФОРУМЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хороо, МХЗХҮХ “Дэ Нэйчер Консерванси” байгууллага хамтран “Орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоод болон байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн туршлага солилцох форум”-ыг 2025 оны 11 сард зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр байгаль орчноо хамгаалах үйлс дэх нутгийн иргэдийн оролцоог иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихтэй холбож буй байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд болон хадгаламж, зээлийн хоршоод туршлага, сорилт, боломж, амжилтаа хуваалцлаа.




# 8

## “МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛ”-ИЙГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛАЛАА

Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/76 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооноос дэд ахлагчаар ажиллаж, зохицуулалттай 8 салбарын 9 модулийг үнэлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн МУТА-ны 2 албан хаагч гадаад улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд үнэлгээ хийх багт үнэлгээчнээр ажиллалаа

# 9

## САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ УИХ-Д ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ



Тус хуулийн төсөл нь эрсдэлээс хамгаалагдсан, орон нутгийн иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан, санхүүгийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлагад нийцсэн мэргэжлийн санхүүгийн байгууллага болгон хөгжүүлэх зорилготой юм.



# 10

## **НАМИБИЯ УЛСЫН ТӨВ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛ УЛСЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТАЙ ТАНИЛЦЛАА**

Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Намибия Улсын Төв банкны төлөөлөгчид Монгол Улсын ногоон болон хүртээмжтэй санхүүжилтийн бодлого, зохицуулалт, тогтвортой санхүүгийн хөгжлийн туршлагатай танилцах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороонд ирж ажиллалаа. Айлчлалын үеэр ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, зохицуулалтын туршлагын талаар санал солилцов.

01

БҮТЭЦ, ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

---

01

## БИДНИЙ ТУХАЙ


Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

### АЛСЫН ХАРАА

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно.


### ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.



Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2006 онд Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталж Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоож өгснөөр үйл ажиллагаагаа 2006 онд эхлүүлсэн. Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 онд 9 газар, 4 хэлтэс, 6 албаны 190 албан хаагчдийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Зураг 1. Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЛБАН ХААГЧИД

Санхүүгийн зохицуулах хороонд тайлант онд төрийн тусгай албан хаагч 3, төрийн захиргааны албан хаагч 179, төрийн үйлчилгээний албан хаагч 4, гэрээт ажилтан 4 ажилласан байна.

### ХҮЙСЭЭР



### БОЛОВСРОЛЫН ЗЭРГЭЭР



**3**  
ДОКТОР


**74**  
МАГИСТР

**112**  
БАКАЛАВР


**1**  
БҮРЭН ДУНД

## ХҮНИЙ НӨӨЦ

### Мэргэжил



### Албан хаагчдын насны байдал




### Албан хаагчдын ажилласан жилээр



### Мэргэшүүлэх сургалт

Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц, богино, дунд хугацааны сургалтад нийт 36 албан хаагч хамрагджээ.



## Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаа



Төрийн албаны тухай хуульд “төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” болон “Сургалтын хөтөлбөр”-ийг тус тус баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

## Нийгмийн баталгаа, эрүүл мэнд

- Албан хаагчдын цэцэрлэгийн насны хүүхдүүд Нийслэлийн 5 дугаар цэцэрлэгт хамрагдаж байна.
- Ахмад ажилтнуудад Сар шинийн баяр, Үндэсний их баяр наадам, Ахмадын баярыг тохиолдуулан тэтгэмж олгож, буцалтгүй тусламж үзүүлэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулав.
- Хорооны эмч албан хаагчдад эмийн болон эмийн бус нийт 1,283 удаагийн эмчилгээ, үйлчилгээ үзүүллээ.



## Албан хаагчдыг идэвхжүүлэх



### “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Зохицуулалттай салбарын 13 холбоодыг уриалан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 769 мод тарилаа.



### Цус хандивлах аянд нэгдэв

Цус хандивлах сайн дурын үйл ажиллагаанд 40 орчим албан хаагч идэвхтэй хамрагдлаа.



### “Эрүүл агаар – Идэвхтэй алхалт”

Намрын алхалтыг 2025.09.30–ны өдөр зохион байгуулав.

## Албан хаагчдын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор



**Спортын наадам:** Албан хаагчдын дунд “Спортын Их наадам–2025” спортын 5 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны шигшээ баг УИХ–ын харьяа болон Сангийн сайдын нэрэмжит, Хорооны

зохицуулалтын салбаруудын нэр бүхий 12 удаагийн тэмцээнд, спортын 7 төрлөөр өрсөлдөж 2 удаа аваргын цом, 10 алт, 10 мөнгө, 12 хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо. Мөн “Шилдэг тоглогч”–оор 10 албан хаагч шалгарав.

02

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

---



## ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТУУД

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой **29** хууль болон **51** дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

**Хүснэгт 1.** Үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хуулиуд

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Дагаж мөрдөх огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон тоо	Төрийн мэдээлэл эмхэтгэл
<b>Нийт салбарт хамаарах</b>					
1	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль	2005–11–17	2005–12–17	11	2005 он, №46
2	Захиргааны ерөнхий хууль	2015–06–19	2016–07–01	9	2015 он, №28
3	Компанийн тухай хууль	2011–10–06	2011–11–21	7	2011 он, №42
4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	2013–05–31	2013–05–31	4	2013 он, №24
5	Валютын зохицуулалтын тухай хууль	1994–05–12	1994–06–01	5	1994 он, №6
6	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль	2009–07–09	2009–07–09	1	2009 он, №28
7	Зөвшөөрлийн тухай хууль	2022–06–17	2023–01–01	–	2022 он, №38
8	Банкны тухай хууль	2010–01–28	2010–01–28	23	2010 он, №7
9	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	2003–01–03	2003–01–03	6	2003 он, №2
10	Зөрчлийн тухай хууль	2017–05–11	2017–07–01	28	2017 он, №24
11	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	2017–05–18	2017–07–01	14	2017 он, №24
<b>Даатгалын салбар</b>					
12	Даатгалын тухай хууль	2004–04–30	2005–06–01	12	2004 он, №20
13	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	2004–04–30	2005–06–01	5	2004 он, №20
14	Жолоочийн даатгалын тухай хууль	2011–10–06	2012–01–01	5	2011 он, №43
15	Малын индексжүүлсэн даатгалын тухай	2014–06–13	2014–07–20	1	2014 он, №26
16	Үрийн тариалангийн даатгалын тухай	1999–07–02	2000–01–01	4	1999 он, №31
<b>Үнэт цаасны салбар</b>					
17	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	2013–05–24	2014–01–01	7	2013 он, №24
18	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль	2013–10–03	2014–01–01	1	2013 он, №41
19	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль	2010–04–23	2011–01–01	1	2010 он, №20
20	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	2011–06–02	2012–06–01	5	2011 он, №25
21	Инновацийн тухай хууль	2012–05–22	2012–07–05	7	2012 он, №24
22	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль	2023–01–20	2023–03–01	–	2023 он, №09
<b>Банк бус санхүүгийн байгууллагын салбар</b>					
23	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль	2002–12–12	2003–02–01	9	2002 он, №48
24	Зээлийн батлан даалтын сангийн тухай	2012–02–10	2012–02–10	2	2012 он, №9
25	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	2021–05–21	2021–07–01	1	2021 он, №27
<b>Хадгаламж, зээлийн хоршооны салбар</b>					
26	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль	2011–10–27	2011–11–05	1	2011 он, №46
<b>Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбар</b>					
27	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	2021–12–17	2021–12–17	–	2022 он, №6
<b>Мөнгөн зээлийн үйлчилгээ эрхлэгчийн салбар</b>					
28	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль	2022–11–04	2023–03–01	–	2022 он, №49
<b>Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагчийн салбар</b>					
29	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль	2022–12–23	2023–06–30	–	–

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй Санхүүгийн зохицуулах хорооны дангаар болон бусад байгууллагатай хамтран баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг салбараар ангилбал:

Дангаар баталсан – 36



Зохицуулалтын салбаруудын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараахь арга хэмжээ авсан. Үүнд:

**Хүснэгт 2.** Авсан арга хэмжээнүүд

Салбарын нэр	Шинээр баталсан	Шинэчлэн баталсан	Нэмэлт өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
Үнэт цаас	4	6	4	9
Даатгал	–	2	–	2
ББСБ	–	4	2	2
ХЗХ	–	–	–	1
МЗҮАЭ	–	1	–	–
ВХҮҮ	–	1	1	1
Нийт салбарт хамаарах	–	–	7	–

## ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны **2025** оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, ЗГХЭГ–ын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлал, зааврын дагуу боловсруулж нийт **160** зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр **95.0** хувийн үнэлгээтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны **2022–2025** оны стратеги төлөвлөгөө **4** зорилго, **9** зорилт тэдгээрийг хэрэгжүүлэх **75** арга хэмжээтэйгээр батлагдан, стратегийн хэрэгжилтийн явц нийтдээ **92.2** хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлж, хугацаа нь тайлант онд дуусгавар болж байна. Энэхүү стратегийн хүрээнд хэрэгжүүлсэн **75** арга хэмжээний биелэлтийг авч үзвэл, **81** ба түүнээс дээш хувийн биелэлттэй **61**, **51–80** хувийн биелэлттэй **10**, харин **50** ба түүнээс доош хувийн биелэлттэй 4 арга хэмжээ байна.

### ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

#### Хүснэгт 3. Хэрэгжилт

№	Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1	“Алсын хараа 2050” МУ–ын Урт хугацааны хөгжлийн бодлого	31	87.3 %
2	Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	4	93.8%
3	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө /Тэргүүлэх чиглэл/	6	97.5%
4	Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	4	85.1%
5	Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	4	86.7%
6	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл	7	85.7%
7	Шинэ сэргэлтийн бодлого	1	100%
8	Монгол Улсын Их хурлын 79 дүгээр тогтоолоор батлагдсан Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээ	2	100%
9	Монгол улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр	69	94.0%
10	Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг	56	56.1%

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААН, ШИЙДВЭР

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. “Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна” гэж заасан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 231 дүгээр тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг мөрдөн 21 удаагийн хуралдаан зохион байгуулж асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж тогтоол, хуралдааны тэмдэглэлээр үүрэг даалгавар албан ёсоор гаргасан байна.

Тогтоолыг ангилбал дараах байдалтай:



**48** БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТ

<b>4</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>10</b>
Шинээр баталсан журам	Шинэчлэн баталсан	Нэмэлт, өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон	Хамтарсан тушаалаар батлах	Зөвшөөрөл олгосон	Бусад



**461** БҮРТГЭЛ,  
ЗӨВШӨӨРӨЛ


<b>153</b> Тусгай зөвшөөрөл	<b>30</b> Энгийн зөвшөөрөл	<b>18</b> Сэргээсэн	<b>5</b> Нэгтгэж, хүчингүй болгосон
<b>77</b> Түдгэлзүүлсэн	<b>110</b> Хүчингүй болгосон	<b>15</b> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт	
<b>6</b> Зохицуулалттай этгээдээр бүртгэх	<b>12</b> Аудит, хууль зүйн зөвлөгөө, хөрөнгийн үнэлгээний хуулийн этгээдэд эрх олгох	<b>19</b> Үнэт цаасны бүртгэл	
<b>15</b> Хөрөнгө оруулалтын сангийн баримт бичиг	<b>1</b> Бусад		

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТУШААЛ

Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 3.2. "Хорооны дарга хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд тушаал гаргах эрхтэй." гэж заасны дагуу тайлант онд 509 тушаал баталж, хэрэгжилтийг хангуулсан байна.



Мөн дүрмийн 4.5. дахь хэсэгт "Ажлын албаны дарга нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18.3-т зааснаас гадна дор дурдсан эрх, үүрэгтэй" гэж заасны дагуу тайлант онд Ажлын албаны даргын 393 тушаал батлагдаж, хэрэгжилтийг хангаж ажилласан.



03

САНХҮҮГИЙН  
ЗАХ ЗЭЭЛ

---

03

## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхийн эдийн засаг **2025** онд **3.2** хувиар өссөн ба хөгжиж буй болон эрчимтэй хөгжиж буй орнууд **4.2** хувийн өсөлтийг үзүүлж, өндөр хөгжсөн орнуудын эдийн засаг **1.6** хувийн өсөлт үзүүлэв.

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2025 онд 130.4 их наяд ам.долларт хүрч, өмнөх оноос 22.2 хувиар өссөн байна. Үүнээс АНУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ойролцоогоор 61.8 их наяд ам.доллар буюу дэлхийн нийт зах зээлийн 47.4 хувийг эзэлд дараагаар нь БНХАУ 11.9 их наяд ам.доллар, Япон 6.4 их наяд ам.доллар, Их Британи 4.4 их наяд ам.долларын үнэлгээгээр жагсав.

### БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024 онд дэлхийн бичил санхүүгийн зах зээл нь ойролцоогоор 279.2 тэрбум ам долларын үнэлгээтэй байсан бол 2025 онд 310.1 тэрбум ам доллар болж, өмнөх оноос ойролцоогоор 11.1 хувиар өссөн байна. Өсөлтийн гол хүчин зүйл нь санхүүгийн хүртээмж, дижитал үйлчилгээний өргөжилт, жижиг бизнесүүд болон өрхүүдийн зээлийн шаардлага нэмэгдсэнтэй холбоотой байв.

### ВИРТУАЛ ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

2025 оны 3 дугаар улиралд дэлхийн крипто зах зээлийн нийт үнэлгээ түүхэн дээд түвшинд хүрч, 4.0 их наяд ам.долларыг давсан байна. Гэвч 2025 оны 10 дугаар сард зах зээлд 19 тэрбум ам.долларын түүхэн дэх хамгийн том албадан татан буулгалт явагдсанаар ханш огцом унаж, зах зээлийн үнэлгээ эрс буурахад хүргэсэн. Үүний үр дүнд 2025 оны эцсийн байдлаар дэлхийн крипто зах зээлийн нийт үнэлгээ ойролцоогоор 3.0 их наяд ам.долларын түвшинд байна.

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн нийт даатгалын хураамжийн орлого 2024 онд ойролцоогоор 8.2 их наяд ам.доллар хүрсэн ба 2025 онд даатгалын зах зээлийн өсөлт ойролцоогоор 2 хувиар нэмэгдэх төлөвтэй. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин 2024 онд 7.4 хувь байсан бөгөөд 2025 онд уг түвшин ерөнхийдөө тогтвортой хадгалагдах төлөвтэй байна.

### ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АГЕНТЛАГ, БРОКЕРЫН ЗАХ ЗЭЭЛ

Үл хөдлөх хөрөнгийн агентлаг болон зуучлалын зах зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд өндөр өсөлт үзүүлсэн. Тус зах зээл 2024 онд 1.5 их наяд ам.доллар байсан бол 2025 онд 1.6 их наяд ам.долларт хүрч, жилийн нийлмэл өсөлт 6.9 хувьтай байх төлөвтэй байна. Өмнөх хугацаанд ажиглагдсан энэхүү өсөлт нь хөгжиж буй зах зээлүүдийн эдийн засгийн тэлэлт, өрхийн орлогын өсөлт, мөн төрийн бодлогын дэмжлэг, хэрэгжүүлсэн санаачилгуудын үр нөлөөтэй шууд хамааралтай юм.



## ДЭЛХИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН


Олон улсын валютын сан (IMF)-ийн “World Economic Outlook” тайланд дурдсанаар, дэлхийн нийт дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 онд 117.2 их наяд ам.долларт хүрч, өмнөх оноос ойролцоогоор 3.3 хувиар өссөн ба уг өсөлтөд АНУ, БНХАУ тэргүүтэй дэлхийн топ 4 эдийн засгууд голлон нөлөөлж, нийт дотоодын нийт бүтээгдэхүүний талаас илүү хувийг эзэлж байна.

### АНУ – ДНБ 30.6 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР

2025 онд АНУ-ын ДНБ 2.1 хувиар өсөж 30.6 их наяд ам.долларт хүрсэн нь төсвийн бодлогын дэмжлэг, бодлогын хүү буурч санхүүжилтийн нөхцөл зөөлөрсөн байдал, мөн технологийн салбарын өсөлт эдийн засгийн идэвхийг хадгалсантай холбоотой.

### БНХАУ – ДНБ 19.4 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР

БНХАУ-ын эдийн засаг 2025 онд төсвийн болон мөнгөний бодлогын идэвхжил, хөрөнгө оруулалтад чиглэсэн банкнуудын нэмэлт санхүүжилтийн нөлөөгөөр 5.0 хувиар өсөж, ДНБ нь 19.4 их наяд ам.долларт хүрсэн байна.



### ЯПОН – ДНБ 4.2 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР

Японы эдийн засаг 2025 онд 1.1 хувиар өсөж, ДНБ нь 4.2 их наяд ам.долларт хүрсэн байна. Үүнд шинэ засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих төсвийн багц бодлогын нөлөө тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.

### GERMAN УЛС – ДНБ 5.0 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР

Германы ДНБ 2025 онд 0.2 хувиар өсөж 5.0 их наяд ам.долларт хүрсэн нь төрийн зардал нэмэгдсэн, дотоод эрэлт харьцангуй тогтвортой байсан болон Евро бүс доторх гол эдийн засаг байршлын давуу талтай холбоотой. Гэсэн хэдий ч өндөр эрчим хүчний үнэ, бүтцийн сул талуудын нөлөө үргэлжилж байгаа нь дунд хугацаанд өсөлтийг хязгаарлах хүчин зүйл хэвээр байна.

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар) 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр 89.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 9.3 их наяд төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2.2 их наяд төгрөгөөр (36.7 хувь), үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 4.1 их наяд төгрөгөөр (11.5 хувь), мөн үйлдвэрлэл, барилгын салбарын нэмэгдэл өртөг 2.0 их наяд төгрөгөөр (22.4 хувь) голлон нөлөөлжээ.

 **5.9%** Эдийн засгийн өсөлт

 **\$7** Гадаад валютын улсын нөөц  
тэрбум

 **7.5%** Инфляцын түвшин

 **\$4.4** Гадаад худалдаа Тэнцэл  
тэрбум

 **12%** Бодлогын хүү

 **\$1.0** Төлбөрийн тэнцэл  
тэрбум

 **5.6%** Ажилгүйдлийн түвшин

 **62.3%** Ажиллах хүчний оролцоо

 **121.8%** Санхүүгийн зах зээлийн ДНБ-д тэнцэхүйц хувь

## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2025 онд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны салбарын нийт хэмжээ ДНБ /үйлдвэрийн аргаар тооцсон дүнд/-д эзлэх 26.8 хувьд тэнцэхүйц хэмжээнд хүрэв.

Уг өсөлтөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, **15.4%**

ББСБ-ын салбарын нийт хөрөнгө **10.1%**

ГОЛЛОН НӨЛӨӨЛСӨН БОЛНО.

Зураг 4. Санхүүгийн салбарын зохицуулалттай этгээдүүд

# 26.8%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, НИЙТ ХӨРӨНГӨ НЬ ДНБ-Д



ХӨРӨНГИЙН  
ЗАХ ЗЭЭЛ

$$15.4\% = \frac{\text{Зах зээлийн үнэлгээ}}{\text{ДНБ}}$$



ДААТГАЛЫН  
ЗАХ ЗЭЭЛ

$$0.9\% = \frac{\text{Нийт хөрөнгө}}{\text{ДНБ}}$$



БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГА

$$10.1\% = \frac{\text{Нийт хөрөнгө}}{\text{ДНБ}}$$



ХАДГАЛАМЖ,  
ЗЭЭЛИЙН ХОРШОО

$$0.4\% = \frac{\text{Нийт хөрөнгө}}{\text{ДНБ}}$$

## ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАР

Санхүүгийн зохицуулах хороо нь 2006 онд байгуулагдсан цагаасаа эхлэн үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо гэсэн дөрвөн санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулалтын салбарын тоо нэмэгдэж **2025** онд санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн **11** салбар болж хүрээгээ тэлсээр байна.

### 2006

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

### 2020 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн

2006	2020	2021	2022	2025
4	6	8	9	11

## ЗОХИЦУУЛАЛТАЙ САЛБАР | НИЙТ 11 САЛБАР



### 2020

Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт

- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



### 2021

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт  
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, СТБЗ–ийн 2021 оны хамтарсан тушаал

Системийн нөлөө бүхий банкнууд олон нийтэд нээлттэй болох

Сэндбокс орчны зохицуулалт



### 2022

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч



### 2023

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд


Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналт зохицуулалт

## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Санхүүгийн зохицуулах хороо 2025 оны байдлаар санхүүгийн 11 салбарын 5,930 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавин ажиллаж байна.

Зураг 3. Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд




## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээлд нийт 634 зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.


Тайлант онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд буюу **13.9** их наяд төгрөгт хүрч өмнөх оноос **6.6** хувиар буюу **856.7** тэрбум төгрөгөөр өссөн. Энэ нь үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний **15.6** хувьтай тэнцэж байна.

**Зураг 4.** Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



2025 онд **1,315.5** тэрбум төгрөгийн үнэт цаас арилжигдсан нь өмнөх оноос **16.7** хувиар, 2021 оноос **7.0** хувиар тус тус буурсан үзүүлэлт юм. Арилжааны бүтцийг авч үзвэл **28.3** хувийг ХБҮЦ-ны, **24.6** хувийг компанийн бондын, 21.8 хувийг хувьцааны, **14.3** хувийг ХОС-гийн нэгж эрхийн, **11.0** хувийг ЗГДҮЦ-ны арилжаа тус тус эзэлж байна. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар **2.1** хувьтай байна.


**Зураг 5.** Нийт арилжааны дүн



## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖ

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт **619** удаагийн арилжаагаар **27.8** сая тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалагдлаа. Нийт **7,350.4** тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн арилжигдсан нь өмнөх оноос **17.4** хувиар буурсан үзүүлэлт юм. Арилжааны үнийн дүнгийн **76.0** хувийг нүүрс, **18.2** хувийг төмрийн хүдэр, төмрийн баяжмал, **5.1** хувийг зэсийн баяжмал, **0.7** хувийг хайлуур жоншны арилжаа тус тус эзэлж байна.


**Зураг 6.** УУББ-ийн арилжааны дүн



## БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Биржийн бус зах зээлд нийт **125** үнэт цаас гаргагчийн **405** транч **150** өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс төгрөгөөр **2,385.1** тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж бодитоор **1,589.6** тэрбум төгрөгийг татан ам.доллараар **84.0** сая ам.долларын үнийн дүнтэй өрийн хэрэгсэл бүртгэж, **63.9** сая ам.долларыг тус тус татан төвлөрүүлжээ.

**Зураг 7.** Арилжааны дүн /тэрбум төгрөг/



## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ


Даатгалын зах зээлд нийт **22** даатгалын компани, үүнээс **18** ердийн, **3** урт хугацааны, **1** давхар даатгалын компани, **63** даатгалын зуучлагч компани, **29** даатгалын хохирол үнэлэгч компани, **153** аудитор, **40** актуарч, **47** аудитын компани, **1143** даатгалын төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Сүүлийн **5** жилийн байдлаар салбарын нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар **15.1** хувиар даатгалын хураамжийн хэмжээ **23.8** хувиар өсжээ. Малчин айл өрхийг ядуурлаас хамгаалах хүрээнд


малыг ган зудын аюулаас даатгах, зам тээврийн ослын хохирлыг бууруулах, ипотекийн зээлдэгчдийг эрсдэлээс хамгаалах зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Даатгалын салбарын хөгжлийг илтгэх гол үзүүлэлтүүдээс авч үзвэл болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь **0.62** хувь, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ буюу даатгалын нягтрал **163,223** төгрөг байна.


**Зураг 8.** Даатгалын салбарын нийт хөрөнгө, нөөц сан /тэрбум төгрөг/




**Зураг 9.** Даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



**Зураг 10.** Даатгалын хураамж /тэрбум төгрөг/



**Зураг 11.** Өөрийн болон хөрөнгийн өгөөж /тэрбум төгрөг/



## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

Давхардсан тоогоор **36,336** хувьцаа эзэмшигчтэй, **575** Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс **120** ББСБ нь **591** салбар нэгж, **10** төлөөлөгчийн газартай. ББСБ-ууд нь нийт **6,578** ажилтны бүрэлдэхүүнтэйгээр

Монгол Улсын **21** аймаг, **8** дүүрэгт **752.7** мянган зээлдэгчид санхүүгийн үйлчилгээ хүргэж байна. Нийт зээлдэгчдийн **89.1** хувь нь финтек зээлдэгчид болно .


**575** ББСБ | **82** Финтек ББСБ

НИЙТ  
ЗЭЭЛДЭГЧ **752.7** мянга

Давхардсан  
тоогоор **3,153.3**


Зураг 12. ББСБ-ын нийт хөрөнгө /тэрбум төгрөг/

- Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/
- ◻ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/




Зураг 13. ББСБ-ын зээлийн ангилал /тэрбум төгрөг/

- Хэвийн
- Хугацаа хэтэрсэн
- Чанаргүй




Зураг 14. ББСБ-ын чанаргүй зээл ба ЗЖДХ /тэрбум төгрөг/

- Чанаргүй зээл
- ЗЖДХ



Зураг 15. ББСБ-ын нийт орлого, нийт зарлага /тэрбум төгрөг/

- Цэвэр орлого
- Нийт орлого
- Нийт зарлага




## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

Монгол Улсын хэмжээнд **176** Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) болон тэдгээрийн **43** салбар өөрсдийн гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс ХЗХ-ны **82** нь Улаанбаатар хотод, **94** нь орон нутагт бүртгэлтэй байна. ХЗХ-дын гишүүдийн тоо өмнөх оноос **2.5** хувиар өсөж


**77,155** болжээ.

Мөн гишүүдийн оруулсан хувь хөрөнгө өмнөх оноос **4.8** хувиар өсөж **30.3** тэрбум төгрөгт, хоршоолгчдын өмч **14.8** хувиар өсөж **61.3** тэрбум төгрөгт хүрлээ.


Зураг 16. ХЗХ-ны нийт хөрөнгө




Зураг 17. ХЗХ-ны нийт зээл



Зураг 18. ХЗХ-ны хөрвөх чадвар



Зураг 19. ХЗХ-ны зээл болон хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР

Монгол Улсын хэмжээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч /МЗҮАЭ/ **592** байгаагаас **382** нь хууль этгээд, **210** нь иргэн байна. **45** МЗҮАЭ нь **167** салбартай. Эдгээрээс **74** хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй болно. Нийт МЗҮАЭ-ийн **413** нь Улаанбаатар хотод, **179** нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

МЗҮАЭ-ийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ **1,421.1** тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл **840.6** тэрбум төгрөг байгаагаас **12.9** хувь буюу **108.4** тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Зураг 20. Нийт хөрөнгө ба зээл /тэрбум төгрөг/




## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Тус салбарт 289 ҮХЭХЗ-ын байгууллага тэдгээрийн 1,192 агент, 303 брокер бүртгэлтэй байна. Эдгээр зуучлалын байгууллага нь 2025 оны байдлаар 425 хувьцаа эзэмшигчдийн 5.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 25.6 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашиг, 221.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэллээ. Өмнөх онтой харьцуулахад хуримтлагдсан ашиг 14.7 хувиар,


нийт хөрөнгө 1.5 хувир тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Үл хөдлөх хөрөнгийн худалдааны чиглэлээр 4,022.1 мянган м.кв талбайтай, 3,325.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан худалдсан бол 794.1 мянган м.кв талбайтай, 301.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан түрээслүүлжээ.

Зураг 21. Үл хөдлөх хөрөнгийн худалдаа




Зураг 22. Үл хөдлөх хөрөнгийн түрээс



## ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч (ҮМҮЧЭТХЭАЭ)-ийн салбарт **52** хуулийн этгээд, **504** иргэн үйл ажиллагаа эрхэлж байна. ҮМҮЧЭТХЭАЭ-чид **2025** оны байдлаар **2.1** тонн үнэт металлыг **615.2** тэрбум

төгрөгөөр худалдан авч, **1.7** тонн үнэт металлыг **636.6** тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан. Мөн **57.9** тэрбум төгрөгийн үнэ бүхий үнэт эдлэлийг худалдан авч, **80.1** тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулжээ.



## ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАР

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)-ийн салбар нийт **53.9** тэрбум төгрөгийн хөрөнгөтэй **12** хуулийн этгээд үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр ВХҮҮ-ээр дамжуулан нийт **770** виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаагаас **4.8** хувь буюу **37** нь дотоодын виртуал хөрөнгө байна.

Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ **250.0** тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос **8.3** тэрбум төгрөг буюу **3.2** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Давхардсан тоогоор **709,567** харилцагч ВХҮҮ-д бүртгэлтэй бөгөөд үүнээс **2.6** хувь буюу **18,463** нь арилжаанд идэвхтэй оролцож байна.

**Зураг 23.** Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



## СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Сэндбокс зохицуулалтын орчинд ББСБ-уудын хоорондох репо хэлцлийн үйлчилгээ, хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, итгэлцлийн үйлчилгээ, P2P зээлийн үйлчилгээ, краудфандинг буюу хамтын санхүүжилтын үйлчилгээ, биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем болон богино хугацаат санхүүжилтын зуучлал B2B зээлийн үйлчилгээ гэсэн **8** бүтээгдэхүүн, үйлчилгээ туршигдлаа. Түүнчлэн нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн үйлчилгээ сэндбоксын зохицуулалтын орчинд шинээр туршигдахаар орлоо.

ББСБ-уудын хоорондох репо хэлцлийн арилжаанд **41** зээлдүүлэгч, **39** зээлдэгч оролцож, нийт **190.1** тэрбум төгрөгийн 806 удаагийн арилжаа хийжээ. Краудфандинг буюу хамтын санхүүжилтийн

үйлчилгээ нь нийт **2.6** тэрбум төгрөгийн **64** төсөл нийтэлснээс **354.1** сая төгрөгийн санхүүжилт амжилттай татан төвлөрүүлсэн байна. B2B зээлийн үйлчилгээний хувьд нийт **37** харилцагчид **106.1** тэрбум төгрөгийн зээл зуучилсан бол P2P зээлийн үйлчилгээгээр **769.5** сая төгрөгийн зээлийг **1,717** зээлдэгчид зуучилсан байна. Харин биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны системийн хувьд сэндбоксын туршилтын хугацаанд нийт **28.3** тэрбум төгрөгийн дүн бүхий **261,540** ширхэг үнэт цаасны арилжаа хийсэн бол блокчэйн системд бүрэн шилжсэний дараа **1,131,211** ширхэг үнэт цаасыг **668.1** тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд, **1,072,531** ширхэг үнэт цаасыг **584.5** тэрбум төгрөгөөр хоёрдогч зах зээлд тус тус арилжаалав.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2021 | Ногоон бондын зохицуулалтын орчин бүрдсэн.

2022 | “Бонз тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг олон нийтэд хүргэсэн.

2025 | Нийгмийн болон тогтвортой бондын зохицуулалтын орчин бүрдсэн.



АНХНЫ “ЖЕНДЕР БОНД” БҮРТГЭСЭН.

## НОГООН, НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ БОНД

Зураг 24. Олон улсын болон дотоодын ногоон, нийгмийн тогтвортой бондын эзлэх хэмжээ

Олон улсын ногоон, нийгмийн бонд

85.8 %

340

сая ам.доллар

Дотоодын ногоон, нийгмийн бонд

14.2 %

56.2

сая ам.доллар

Зураг 25. Дотоодын бондын төрөл

НИЙГМИЙН БОНД

8.4 сая

ам.доллар

НОГООН БОНД

47.8 сая

ам.доллар

Зураг 26. Дотоодын ногоон бондын татан төвлөрүүлсэн дүн

“ХААН БАНК” ХК

30 сая ам. доллар

ТЖТБ ХХК

15 сая ам. доллар

ТӨРИЙН БАНК ХК

10 тэрбум төгрөг

Зураг 27. Биржийн болон биржийн бус зах зээлд арилжаасан дүн

БИРЖИЙН  
ЗАХ ЗЭЭЛ

53.3 сая

ам.доллар 94.8%

БИРЖИЙН  
БУС ЗАХ ЗЭЭЛ

2.9 сая

ам.доллар 5.2%

Жендер бондын татан төвлөрүүлсэн дүн



30

тэрбум  
төгрөг

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

12 ХЗХ  
160  
оролцогч



Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд болон ХЗХ-дын туршлага солилцох форум”-ыг 2025.11.14-ний өдөр АНУ-ын The Nature Conservancy (TNC)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан.

Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд ХЗХ-дод зориулсан хүртээмжтэй ногоон болон жендерийн мэдрэмжтэй санхүүгийн гарын авлага боловсруулж гаргасан.

2024 оны 2 дугаар улирлаас эхлэн ногоон зээлийн судалгааны тайланг авч эхэлсэн.

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


ББСБ–уудын ногоон зээлийг 5 хувьд хүргэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, 2022 оны 1 дүгээр улирлаас “Монгол Улсын Ногоон таксономи”–д нийцсэн ногоон зээлийн тайланг авч эхэлсэн.

Ногоон зээлийн үлдэгдэл 2022 оны эцсийн байдлаар 117.4 тэрбум төгрөгөөс 2025 онд 152.7 тэрбум төгрөгт хүрч 1.3 дахин өссөн байна.

**65%–80%**  
НОГООН ЗЭЭЛИЙН  
БАГЦААС  
ХАМААРАН

ББСБ–ын ногоон зээлийн багцын эзлэх хувиас хамааран итгэлцлээр татах эх үүсвэрийн хэмжээг өөрийн хөрөнгөд харьцуулсан дүнгээр 80 хүртэлх хувь байхаар нэмэгдүүлж, ялгамжтай тогтоосон.

Зураг 28. Ногоон зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



**1.3**  
дахин  
өсөлт

## ДААТГАЛ

БОНЗ ТАЙЛАН  
ИРҮҮЛСЭН  
ДААТГАЛЫН КОМПАНИ

18

18 даатгалын компани БОНЗ–ын тайланг ирүүлсэн байна.

НОГООН  
ДААТГАЛЫН  
БҮТЭЭГДЭХҮҮН

7

Ногоон даатгалын 4 шинэ бүтээгдэхүүн бүртгэснээр зах зээлд санал болгож буй ногоон бүтээгдэхүүний тоо 7 боллоо. Ингэснээр иргэдэд байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй даатгалын сонголт нэмэгдэж, тогтвортой хөгжлийг дэмжих санхүүгийн үйлчилгээний цар хүрээ өргөжсөн байна.

## БУСАД

### “ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮЖИЛТИЙН КОД”–Д НЭГДЭВ



“Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн код” (WeCode)–д 2025.04.16–ны өдөр нэгдэн орлоо.



Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкны 2025 оны 367/А–235 дугаар хамтарсан тушаалаар эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн таксономи боловсруулах Ажлын хэсэг байгуулагдлаа.



04

БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТ

---





## БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд хүлээсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлын бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбоотой үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх Бодлогын зөвлөлүүд ажиллаж байна.

### ҮНЭТ ЦААСНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 319 дүгээр тушаалаар “Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.
- 2025.10.01-ний өдрийн хуралдаанаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх “Санал дугаар 1”-ийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.



### ДААТГАЛЫН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 199 дүгээр тушаалаар “Даатгалын бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.
- 2025.11.03-ны өдрийн хуралдаанаар даатгалын баталгаа гаргах үйл ажиллагаатай холбоотой “Даатгалын багц дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг танилцуулсан байна.



### БИЧИЛ САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 449 дүгээр тушаалаар “Бичил санхүүгийн бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.
- 2025.12.18-ны өдрийн хуралдаанаар ББСБ-ын салбарт 2025 онд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээг танилцуулсан.



### МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ


- 2025.02.26-ны өдрийн хуралдаанаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Уг шийдвэрийг ХЗДХЯ-д хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

## ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРЛАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд 2024 онд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс 2025 онд дараах нэр бүхий журмуудыг баталж шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтын орчныг бүрдүүлсэн.




**Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам**



**Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай журам**



**Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам**



**Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам**

## ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖЛЭЭ

Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт орсноор, ТОП-100 аж ахуйн нэгж хөрөнгийн зах зээлд үнэт цаас гарган оролцоход дараах давуу талууд бүрдлээ:

- IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгүүлэхийг шаардахгүй;
- Нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй;
- Нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад заавал андеррайтертай гэрээ байгуулахыг шаардахгүй болно.

**ТОП-100** аж ахуйн нэгжийн төлөөлөл хөрөнгийн зах зээлд:



**“Шунхлай” ХХК 180 тэрбумын төгрөгийн барьцаагүй бонд**



**“Сүү” ХК 5 тэрбум төгрөгийн барьцаагүй бонд тус тус гаргалаа**

## НИЙГМИЙН БОЛОН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОНД ГАРГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс нийгмийн бондын нэгэн төрөл болох жендер бондын зохицуулалтын орчныг бий болгох зорилгоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д ОУСК-тай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр үнэт цаас гаргагчаас дотоодын хөрөнгийн зах зээлд “нийгмийн бонд” болон “тогтвортой байдлын бонд” гаргах боломжийг бүрдүүлсэн.



“Хаан банк” ХК 30 тэрбумын жендер бондыг хөрөнгийн зах зээлд гаргалаа.

## “БОНД ФОРУМ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо 2025.04.17-ны өдөр “Бонд форум” арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү форумын үеэр Санхүүгийн зохицуулах хороо, МҮХАҮТ, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн удирдлагууд дөрвөн талт “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулав.



## “МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ: НЬЮ-ЙОРК 2025”-Д ОРОЛЦЛОО

2025.04.28-ны өдөр “Монголын хөрөнгө оруулалтын форум: Нью-Йорк 2025” арга хэмжээнд оролцож, сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, мөн цаашид гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдэнд үйл ажиллагаа, өсөлтийн боломжоо таниулах чиглэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг танилцуулж, хөрөнгө оруулагчидтай харилцан мэдээлэл солилцов.



## “MONGOLIA'S CAPITAL MARKET CONNECTIVITY-2025” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулан сурталчлах зорилгоор 2023 оноос хойш цуврал болгон зохион байгуулж байгаа “Mongolia's Capital Market Connectivity” арга хэмжээг 2025.09.12-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав.



**БЛОКЧЭЙН СУУРЬТАЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭЧЛЭЛЭЭ СИНГАПУРЫН ФИНТЕК ФЕСТИВАЛЬД ТАНИЛЦУУЛАВ**

Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл Сингапурын финтек фестивальд “Блокчэйн технологид суурилсан биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны шинэчлэл” сэдвээр илтгэл тавьж Монгол Улсын биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог блокчейн технологид бүрэн шилжсэн шинэчлэлийн талаар танилцууллаа.



**“MONGOLIA DAY” ФОРУМ**

Япон Улсад 2025.11.26–ны өдөр зохион байгуулагдсан “Mongolian Day” арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээний талаар танилцуулав.



## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



### ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ БАЙНА

**Даатгалын багц хууль** буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, УИХ–д өргөн барих бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар даатгалын хамрагдалт болон ДНБ–д эзлэх хураамжийн орлогын харьцаа өсөх, дотоодын давхар даатгалын чадавх нэмэгдэж гадагш шилжүүлэх хураамж буурах, зах зээлийн бүтэц тэнцвэржин, олон тулгуурт даатгалын тогтолцоог бүрдүүлэх, технологид суурилсан даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын зах зээлд итгэх итгэл нэмэгдэх зэрэг үр дүн хүлээгдэж байна.



### ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРЛАА

**Ипотекийн даатгалын** хамгаалалт дутмаг байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Даатгалын багц дүрэм”–д өөрчлөлт оруулж, зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалыг урт хугацааны даатгалд төвлөрүүлэх зохицуулалт нэвтрүүлэв. Уг зохицуулалт 2025.08.01–нээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 5,440 шинэ гэрээ байгуулагдсан байна.

**Даатгалын баталгааны зохицуулалт сайжирлаа:** Даатгалын багц дүрмийн 17 дугаар хавсралт, 2, 3, 4, 10 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулснаар дотоодын даатгалын компаниудын баталгааны дээд хэмжээ 4 дахин нэмэгдэж, давхар даатгалын оролцоотойгоор бүх төрлийн баталгаа гаргах боломж бүрдэв.

**Эрүүл мэндийн мэргэжилтний даатгал:** “Эмнэлгийн мэргэжилтний тухай анхдагч хууль”–ийн төсөлд тусгагдсан эрүүл мэндийн ажилтны хариуцлагын даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор холбогдох судалгааг УИХ–ын гишүүн Т.Мөнхсайханд хүргүүлж хамтран ажиллаж байна. Уг хууль батлагдсанаар эрүүл мэндийн салбарын хяналт, хариуцлага болон мэргэжилтнүүдийн нийгмийн хамгаалал сайжрах ач холбогдолтой.

**Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулна:** Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгалын гэрээ, даатгалын нөхөн төлбөр, мэдээллийн ил тод байдал болон бусад зохицуулалтыг боловсронгуй болгохоор “Даатгалын багц дүрэм”–ийн 1, 2, 9, 10, 12 дугаар хавсралтаар баталсан журмуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан, төслийг олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудаст байршууллаа.



### ДААТГАГЧДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО ӨСЛӨӨ

Даатгагчдын хөрөнгийн зах зээл дэх оролцоо нэмэгдэж байна. Тайлант оны байдлаар даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгө оруулалт **87.5** тэрбум төгрөг хүрлээ.

Түүнчлэн **5** даатгалын компани олон нийтэд нээлттэй, хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байна. **2025** оны байдлаар даатгалын салбар дахь хувьцаа эзэмшигчдийн тоо **28,261** байна.



### ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ӨРГӨЖСӨӨР БАЙНА

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын дагуу даатгалын компаниуд 2024 оны 8 дугаар сараас эхлэн баталгаа гаргаж эхэлсэн бөгөөд 2025 оны байдлаар 10 даатгалын компани нийт **611.8** тэрбум төгрөгийн баталгаа гаргаж, **19.8** тэрбум төгрөгийн баталгааны гэрээний төлбөр төвлөрүүлээд байна.



**2025.07.24** –ний өдөр урт хугацааны даатгалын компани **“Коннект лайф”** бүртгэгдсэн.



**2025.11.27** –ны өдөр ердийн даатгалын компани болох **“Үндэстэн Женерал Даатгал”** ХХК бүртгэгдлээ.

### ДААТГАЛЫН САЛБАРТ ЗАЛИЛАНГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗАХ ЗЭЭЛ ДЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БАГАСГАХ СЭДВЭЭР ХЭЛЭЛЦЛЭЭ



2025.05.26–ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгалын зах зээлийн холбоо хамтран “Зах зээлийн эрүүл хөгжлийг дэмжих: Залилангаас сэргийлэх цогц тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтыг Хонконг, Сингапур дахь IBNR Management Consulting компанийн Ази тивийг хариуцсан захирал ноён Рудольф Фрай удирдан явуулсан бөгөөд сургалтад даатгалын салбарын удирдлагууд, нөхөн төлбөрийн албаны мэргэжилтнүүд хамрагдлаа.



Сургалтаар даатгалын залилангийн өнөөгийн нөхцөл байдал, зах зээлд нөлөөлөх сөрөг нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох аргачлал бүхий цогц тогтолцоог бүрдүүлэх, үүнд салбарын бүх оролцогчдын үүрэг оролцоо чухал талаар иж бүрэн мэдлэгийг олгосон юм.


# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР



## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, тандан судалгаа, нөлөөллийн шинжилгээг шинэчлэн боловсруулан УИХ-ын дарга болон ЭЗБХ-ны гишүүдэд танилцууллаа.




### САЛБАРЫН ЖУРАМ БАТАЛЛАА.



2025.02.25-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, 69 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай”, 70 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарь”, 71 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Мөн 2025.12.25 өдрийн 503 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг, 504 дүгээр тогтоолоор итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг баталлаа.

### ӨР ОРЛОГЫН ХАРЬЦААГ ТООЦОХ АРГАЧЛАЛ БАТАЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 186 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ыг шинэчлэн баталсан.

### БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭРТ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2025.03.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх эх үүсвэр нь өөрийн хөрөнгийн 80 хувь байсныг 60 хувь, өөрийн бичиг өөрийн хөрөнгийн 50 хувь байсныг 30 хувь болгож, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас өөрийн хөрөнгийн 60 хувьд, буюу дотоодын арилжааны банк болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх хязгаарлалт тогтоолоо.

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

### САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ УИХ–Д ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/–ийн төсөлд d.parliament.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтээс санал авч, олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг Дархан–Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Дорноговь, Дундговь аймаг болон Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан.

УИХ–ын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар хамтран санаачилсан тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдөр УИХ–д өргөн мэдүүлсэн.




### АЗИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН 9 ДЭХ УДААГИЙН ХУРАЛД ОРОЛЦЛОО

Тайландын Хаант Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан “Өнөөгийн хэрэгцээ ба ирээдүйн боломж” сэдэвт Азийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагч байгууллагуудын 8 дахь удаагийн хуралд 2025.02 сард оролцож салбарын ирээдүйн чиг хандлага болон зохицуулагч байгууллагын сайн туршлагыг хуваалцсан. Хурлаар Азийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын нийгэмлэг (ACCRA)–ийн удирдах зөвлөлийг шинээр томилсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо дэд даргаар томилогдлоо.



### АЗИ–НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГИШҮҮН ОРНУУДЫН ЦАХИМ УУЛЗАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ази–Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын цахим уулзалтыг 2025.07 сард зохион байгуулсан. Тус уулзалтад Пакистан, Узбекистан Улсын төв банк болон Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (МХЗХҮХ)–оос төлөөллүүд оролцож ХЗХ–дын жендер болон ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой туршлагыг солилцсон.



### АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨЛТЭЙ САНАЛ СОЛИЛЦЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Шэннон Коулинтай 2025.10 сард уулзсан ба хадгаламж, зээлийн хоршооны салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх, орон нутгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцлоо.



## ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР

### СТАНДАРТЫН САНАЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАН ХҮРГҮҮЛЭВ

MNS ISO 9202:2025 | MNS ISO 11596:2025 | MNS ISO 15093:2025



Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025.05.28-ны өдрийн тушаалаар үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний стандартын төслийг хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий Үнэт эдлэлийн стандартчиллын техникийн хороо байгуулагдсан. Тус хорооны бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж, Стандарт, хэмжил зүйн газраас боловсруулсан стандартын төслүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох саналыг тусгуулан ажиллалаа.



### ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО

ОХУ-ын Санкт Петербург хотноо 2025.02.05–2025.02.09 өдрүүдэд зохион байгуулагдсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “junwexsaint peterburg 2025” үзэсгэлэнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцож, салбарын талаар мэдээлэл солилцон туршлага судлав.



### АНХДУГААР ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор “Түмэн Эрдэнэс” ГҮТББ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Монгол дархны уламжлал, шинэчлэл” анхдугаар чуулганыг төрийн ордонд зохион байгуулав.

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР



### СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГАТАЙ БОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” болон “Монголын үл хөдлөх хөрөнгө удирдлагын академи” хамтран үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтнүүдэд эрх олгох сургалтын чанарыг сайжруулах, мэргэжлийн оролцогчдын чадварыг бэхжүүлэх, сургалтын хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх ажлын хүрээнд агентын эрх олгох сургалтын гарын авлагыг боловсруулж, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж эхэллээ.



### ОЛОН УЛСЫН ХУРЛУУДАД ОРОЛЦОО

АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн реалторуудын холбоо (National association of Realtors)-оос 2025.05.30–2025.06.05-ны өдрүүдэд Вашингтон хотод зохион байгуулсан “Realtors’ Legislative Meeting–2025” арга хэмжээнд хорооны төлөөлөл оролцлоо.

Улаанбаатар хотноо 2025.07.02–2025.07.05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Re/max франчайзын Ази Номхон далайн бүсийн чуулга уулзалтад оролцлоо.

“Реалторуудын дуу хоолой 2025” арга хэмжээг 2025.06.19-ний өдөр Монголын үл хөдлөх хөрөнгийн академитай хамтран зохион байгууллаа.



### АЖЛЫН ХЭСЭГТ МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭН АЖИЛЛАЛАА

Үл хөдлөх хөрөнгө борлуулахад ногдуулдаг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу Төсвийн байнгын хорооны тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт зуучлалын байгууллагуудаар дамжин худалдан борлуулагдсан үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс болон хэлбэлзлийн мэдээллийг боловсруулан хүргүүлж ажиллалаа.

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР



### СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн боловсролын HUB төвөөс зохион байгуулсан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан цахим сургалтад 2025.12.31–ний байдлаар нийт 2,350 иргэн хамрагдаж сертификат авсан.



Мөн “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”–ыг шинэчлэн баталсантай холбогдуулан аймаг, нийслэлийн бүртгэгч нар т журмын танилцуулга сургалт зохион байгуулж, нийслэлийн 9 дүүрэг болон орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, иргэдэд хууль, журмын онцлог зохицуулалт, тайлан мэдээний цахим системийн талаар мэдээлэл өгөх сургалтыг ЗДТГ болон ЦЕГ–ын Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран зохион байгууллаа.



### ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар баталсан удирдамжаар 2025 онд нийт 3 удаагийн газар дээрх шалгалтыг Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу зүүн 4 замаас сансрын туннел өгсөх зам дагуу, Баянгол дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу Өргөө кинотеатр орчим болон Ард аюушийн өргөн чөлөө замын урд хэсэг, Дорнод аймгийн Хэрлэн суманд хийж гүйцэтгэсэн. Эдгээр шалгалтаар нийт 18 иргэн, 5 хуулийн этгээд нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг хэтрүүлсэн зөрчил илэрсэн тул Зөрчлийн тухай хуулийн 11.34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2–т заасны дагуу хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулсан байна.



Мөн дээрх 3 удаагийн газар дээрх шалгалтаар эрх бүхий этгээдийн бүртгэлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн 20 иргэн, 3 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 11.34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан холбогдох торгуулийн арга хэмжээг ногдуулан, хэрэглэгчийн эрх ашгийг хангуулах чиглэлд ажиллалаа.




### ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЛЭЭ

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан хүлээн авах, боловсруулах, бүртгэх цахим системийг нэвтрүүлж, 2024 оны жилийн эцсээс эхлэн хагас бүтэн жилээр тайлан хүлээн авлаа.

# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАР

## ЖУРАМ ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА




Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 657 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-аас бүртгэх, үйл ажиллагааг түр зогсоох, бүртгэлээс хасажтай холбоотой хэсгүүд болон эрх олголт, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг зэрэг хэсгүүдийг хасаж, журмыг шинэчлэн боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 74 дүгээр тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан.

## ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ

ВХҮҮ–ийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх “Blockchain analytics” систем хэвийн ажиллаж, хяналт шалгалтыг тогтмол явуулж байна. ВХҮҮ–ийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, ханшийн мэдээллийг өдөр бүр API системээр хүлээн авч 7 хоног, сар бүр нэгтгэн, хяналт тавьж ажиллалаа.

ВХҮҮ–ийн хяналт, зохицуулалтын чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албатай хамтран “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг үнэлэх газар дээрх хяналт, шалгалтын удирдамж”-ийн дагуу бүртгэлтэй 12 ВХҮҮ–д газар дээрх хяналт, шалгалтыг зохион байгуулж, журам, МУТСТ хуулийн хэрэгжилт, хэрэглэгчийг таньж мэдэх, системүүдийн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг зохион байгуулж буй байдал, гүйлгээ болон сэжигтэй гүйлгээг хянаж буй байдал, мэдээллийн ил тод байдал зэрэгт хяналт шалгалт хийлээ.



## УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

ФАТФ–ын Виртуал Хөрөнгийн Харилцаа Холбооны Бүлэг (Virtual Asset Contact Group (VACG))–т Ази, Номхон далайн бүс нутгийг төлөөлөн ажиллаж холбогдох уулзалтуудад тухай бүр оролцож байна. Мөн НҮБ–ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас ирүүлсэн урилгаар 2025.12.04–ний өдөр ВХҮҮ–ийн МУТСТ зохицуулалтын чиглэлээр Палау, Фижи, Тонга улсуудын төлөөлөлд цахимаар илтгэл тавьж туршлага хуваалцлаа.



## СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



Санхүүгийн зохицуулах хороо нь технологид суурилсан шинэ, шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг өөрийн хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгож байна.



### СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО

Сэндбоксын зөвлөлийн ээлжит 8,9-р хуралдаан 2025.01.19 болон 2025.12.23-ны өдрүүдэд болж “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах, Сэндбоксын зохицуулалтын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ турших, туршилтын хугацааг сунгах, зах зээлд нэвтрүүлэх шилжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон сэндбоксын орчноос гарах зэрэг нийт 11 асуудал хэлэлцэж шийдвэрлэлээ.

## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА



“Монгол Улсын финтек салбарыг хөгжүүлэх, инновацийн таатай орчныг бий болгох, хэрэглэгчийг хамгаалах, зайнаас таних, цахим болон тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр” төсөл амжилттай хэрэгжиж дууслаа.

“Азийн Хөгжлийн Банк (АХБ)”-ны санхүүжилттэйгээр Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам хамтран хэрэгжүүлж, төслийн зөвлөхөөр “Access Partnership Ltd” ажилласан бөгөөд боловсруулсан баримт бичгүүд, төслийн үр дүн, хэрэгжилтийг салбарын мэргэжилтнүүдэд танилцууллаа.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг, Бүгд Найрамдах Намиби Улсын Төв банкнаас хамтран зохион байгуулсан “Дэлхийн бодлогын форум”-ын “Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хиймэл оюун ухааны хэрэглээ” сэдэвт хэлэлцүүлэгт, илтгэгч, панелистаар оролцон санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ, зохицуулалт болон Монгол Улсын финтекийн салбар, сэндбокс зохицуулалтын орчны талаар танилцууллаа.



### ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАЛАА

Сэндбоксад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй 4 компани болон сэндбоксын орчинд туршигдаж буй 6 компанийн төлөөлөлтэй нийт 19 уулзалт зохион байгуулж, сэндбоксын орчны талаар болон зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлагын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

### СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 124/75/А/86 дугаар хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-д нэмэлт өөрчлөлт орууллаа. Журмын нэмэлт, өөрчлөлтөөр сэндбоксын орчинд амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулалттай зах зээлд шилжүүлэх үйл явц болон зохицуулалтын орчин бүрдэх хүртэлх хугацааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх талаарх түр зохицуулалт болон сэндбоксын хугацаанд оролцогч үйл ажиллагаагаа түр зогсоох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн тусгай зөвшөөрлийн шаардлагаас зайлсхийх зорилгоор сэндбокс зохицуулалтын орчныг ашиглахыг хязгаарлах зэрэг зохицуулалтыг тусгалаа.

### САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧДЫН МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД



Санхүүгийн зохицуулах хорооноос өөрийн зохицуулалттай салбаруудын мэргэжлийн оролцогчдод зориулсан сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж санхүүгийн салбарын хууль тогтоомж, бодлого, комплаинсын чиглэлээр тогтмол мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.

**Хүснэгт 4.** Зохицуулалтын салбарын ажилчдад зориулж зохион байгуулсан сургалтууд:

Д/д	Сургалтын төрөл	Сургалтын тоо	Оролцогчдын тоо
1	Эрх олгох	43	2,862
2	Мэргэшүүлэх	28	626
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр	32	1,696
4	Мөнгөн зээлийн үйл ажиллагааны чиглэлээр /цахим/	–	2,208



“Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулсан мэргэжлийн холбоодтой хамтарсан 72 удаагийн сургалт зохион байгуулахад 3,488 санхүүгийн зах зээлд оролцогч хамрагдсанаас 2,757 нь тухайн зохицуулалттай салбарт ажиллах болзол,

шаардлагыг хангаж гэрчилгээ гардан авлаа.

Мэргэжлийн оролцогчдод мэргэшүүлэх 28 удаагийн сургалт зохион байгуулж, 626 суралцагч хамрагдсанаас 602-т нь гэрчилгээ олгогджээ.

## ИРГЭД, ОЛОН НИЙТЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД



Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-д **“Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах”** гэж заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилласан.



### МЭДЛЭГ ТҮГЭЭЛЭЭ

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох цахим хуудас, сайт, сонин, телевизээр дамжуулж иргэдэд санхүүгийн мэдлэг олгох зорилгоор нийт 224 мэдээ, ярилцлага, видео нэвтрүүлэг, богино хэмжээний контентыг, Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд түгээсэн.



“Номын баяр”, “Хуульчийн про боно” арга хэмжээнүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ зөвлөгөө мэдээлэл өгч гарын авлага, тараах материалыг олон нийтэд түгээсэн.



## ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР



“Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” нээлттэй хаалганы өдөрлөгийг үнэт цаасны зах зээлийн салбарын дэд бүтцийн байгууллагуудтай хамтран бүсчилсэн байдлаар зохион байгууллаа. Тус арга хэмжээ Баруун бүсийн 4 аймаг, Төвийн бүсийн 5 аймаг, Говийн бүсийн 2 аймаг, Зүүн бүсийн 3 аймаг буюу нийт 14 аймагт амжилттай хэрэгжиж, 10,000 гаруй иргэд хамрагдсан байна.



## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорац, Боловсролын ерөнхий газартай хамтран ахлах ангийн сурагчдын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх “LEVEL-UP” хөтөлбөрийг 2025 оны 1–5 дугаар сард үе шаттай хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт нийслэлийн 6 дүүрэг болон 6 аймгийн нийт 5,033 сурагч, 149 багш хамрагдаж, шилдэг аймаг, сургууль, оролцогчдыг шалгаруулав.



“

СЭЗИС-тэй хамтран санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх чиглэлээр оюутнуудын дунд бүтээлийн уралдаан зарлаж, шилдэг бүтээлүүдийг шалгаруулсан.

”



МУИС, СЭЗИС, Сити их сургуульд “Санхүүгийн зах зээл” мэдлэг түгээх өдөрлөг зохион байгуулж, хөрөнгийн зах зээл, даатгал, хадгаламжийн даатгалын талаар мэдээлэл өгч, асуулт хариултын тэмцээн явуулан шилдэг оюутнуудыг шалгарууллаа. Мөн ажлын байрны танилцуулга хийж, зохицуулах байгууллагуудтай танилцах боломж бүрдүүлэв.





“Өсвөрийн парламент – 2024” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар дүүргийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсролын сургалт зохион байгуулж, зах зээлийн өнөөгийн байдал, үнэт цаас, хөрөнгө оруулалт, эрсдэлийн талаар мэдээлэл өглөө. Үе тэнгийн сурагчдын оролцоотой хэлэлцүүлэг, тэмцээн амжилттай боллоо.


## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, бодлого зохицуулалт, санхүүгийн боловсролын талаар иргэд, олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгохоор **27** удаагийн сургалт зохион байгуулж **17,500** иргэн хамрагдлаа.



Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хөрөнгийн зах зээл”, “Даатгалын ач холбогдол”, “Мөнгөн зээлийн тухай” сэдэвт анхан шатны сургалтыг 6 удаа зохион байгуулж, 800 гаруй оролцогчид санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, зохицуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ болон оролцох боломжийн талаар мэдээлэл олгосон.



Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэдийг санхүүгийн залилан, луйвраас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан хамтран ажиллах зорилготойгоор Цагдаагийн ерөнхий газар, мэргэжлийн 11 холбоотой олон талт санамж бичиг байгуулсан. Тус ажлын хүрээнд Хашир бай аяныг эхлүүлсэн.

05

БҮРТГЭЛ,  
ЗӨВШӨӨРӨЛ

---

05

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ



Тайлант онд **2,628** хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн хүсэлт, баримт бичгийн бүрдлийг хянаснаас анхан шатны бүрдлийг хангасан **306** хүсэлтийг шууд, **1,595** хүсэлт гаргагчид заавар, зөвлөгөө өгч бүрдлийг хангуулан хүлээн авч, шаардлага хангаагүй **727** хүсэлтийг буцаасан. Хүсэлтийн шийдвэрлэлт дараах байдалтай байна. Үүнд:



<p>Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</p> <p><b>8</b></p>	<p>Иргэний тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</p> <p><b>3</b></p>	<p>Иргэний тусгай зөвшөөрлийн үнэмлэх</p> <p><b>3</b></p>	<p>Бүртгэлийн гэрчилгээ</p> <p><b>11</b></p>
<p>Мөнгөн зээлийн бүртгэлийн гэрчилгээ</p> <p><b>6</b></p>	<p>Мөнгөн зээлийн салбарын гэрчилгээ</p> <p><b>3</b></p>	<p>Нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээ</p> <p><b>85</b></p>	<p>Төлөөлөгчийн үнэмлэх</p> <p><b>152</b></p>
<p>Хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</p> <p><b>6</b></p>	<p>Салбарын гэрчилгээ</p> <p><b>36</b></p>	<p>Даатгалын төлөөлөгчийн үнэмлэх</p> <p><b>1538</b></p>	<p>Бусад өөрчлөлт</p> <p><b>912</b></p>



### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдээс **320** хүсэлт ирснийг холбогдох хууль, журмын дагуу хянаж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, үнэт цаас бүртгэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэх зэрэг нийт **271** асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:



#### Тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл:

1	Брокер	<b>2</b>
2	Андеррайтер	<b>1</b>
3	Дилер	<b>2</b>
4	УУББ-ийн брокер	<b>1</b>
5	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох	<b>1</b>
6	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх	<b>3</b>
7	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах	<b>3</b>
8	Мөнгөн хөрөнгийн номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх	<b>1</b>
9	ХБҮЦ гаргах	<b>10</b>
10	Үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдах	<b>2</b>
11	Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх	<b>5</b>
12	Хамтын ХОС	<b>1</b>
13	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	<b>1</b>
14	Үнэт цаасны номиналь данс эзэмших зөвшөөрөл	<b>3</b>
15	Хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл	<b>13</b>



**Бүртгэл болон бусад:**

1	Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаас	1
2	ХБУЦ	11
3	Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгсэл	3
4	Өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаа	1
5	Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичиг	7
6	Мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх	4
7	Оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх	3
8	Тохиромжтой этгээд тодорхойлох	74
9	Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх	9
10	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай /тогтоол/	2
11	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай /тушаал/	11
12	Үнэт цаасны бүртгэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх	2
13	Хорооны албан бичгээр зөвшөөрөл	11
14	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, ХНХ-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах	10
15	Хаалттай өрийн хэрэгсэл	1
16	Хамтын ХОС-гийн нэгж эрхийн танилцуулга	3
17	Хамтын ХОС-г үүсгэн байгуулах баримт бичиг	3
18	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	4
19	ҮЦЗЗ-д оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	1
20	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	5
21	ХНХ-нд хэмжээнд өөрчлөлт оруулах	12
22	Хаягийн өөрчлөлт	18
23	Арилжаалагдаагүй баталгаат үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасах	1
24	Төлөгдөж дууссан өрийн хэрэгслийг бүртгэлээс хасах	6
25	Төлөгдөж дууссан ХБУЦ-ыг бүртгэлээс хасах	8
26	ХОС-гийн дүрэм, бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах	22
27	«ҮЦТХТ» ХХК-д «МҮЦКТ» ХХК-г нэгтгэхийг зөвшөөрч, «МҮЦКТ» ХХК-г бүртгэлээс хасах	1



## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд нийт **242** албан бичгээр ирүүлсэн **512** тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгүүлэх хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэсэн. Үүнд:



### Тусгай зөвшөөрөл:

1	Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1
2	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1
3	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	4
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	19
5	Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох	3

### Эрх олгох:

6	Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай	1
---	---	---

### Зөвшөөрөл болон бүртгэх:

7	Даатгалын компанийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	6
8	Даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээх	26
9	Салбар, төлөөлөгчийн газар бүртгэлээс хасах	19
10	Оноосон нэрийн бүртгэл	2
11	Даатгагчийн эрх бүхий албан тушаалтныг бүртгэх	81
12	Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг хянаж бүртгэх	59
13	Даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьцаа эзэмшигчийг бүртгэх	16
14	Мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтныг бүртгэх	31
15	Хаяг, байршлын өөрчлөлтийг бүртгэх	55



## БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАР



Бүртгэл зөвшөөрлийн чиглэлд банк бус санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн **764** хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль, журмын дагуу хянаж, шийдвэрлэсэн. Үүнд:



### Тусгай зөвшөөрөл:

1	Тусгай зөвшөөрөл олгох тухай	15
2	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох тухай	21
3	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай	11
4	Тусгай зөвшөөрлийг сэргээх тухай	8
5	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох	11
6	Тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн түдгэлзүүлэх тухай	17
7	Тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн хүчингүй болгох тухай	20
8	Тусгай зөвшөөрлийг нэгтгэх, хүчингүй болгох тухай	3
9	Тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн сэргээх тухай	0

**Зөвшөөрөл болон бүртгэх:**

1	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	187
2	Салбар байгуулах тухай	63
3	Оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэх тухай	10
4	Салбар хүчингүй болгох тухай	2
5	Төлөөлөгчийн газар байгуулах тухай	0



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР**



Зөвшөөрлийн цахим системд тусгай зөвшөөрөл хүссэн **7** ХЗХ, сонгуульд гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, салбар, хаяг байршлын өөрчлөлт бүртгүүлэхээр **53** ХЗХ-оос нийт **87** хүсэлт ирүүлснээс **77** хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэсэн. Үүнд:



**Тусгай зөвшөөрөл:**

1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай	7
2	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай	7
3	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай	1
4	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох	9



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР:**



Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд нийт **56** хүсэлт ирүүлснийг холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ. Үүнд:



**Тусгай зөвшөөрөл:**

1	ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох тухай /хуулийн этгээдэд/	3
2	ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох тухай /иргэнд/	36

**Бүртгэл: /Хуулийн этгээдээс ирсэн хүсэлтүүд/**

1	Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	2
2	Салбар нээн ажиллуулах хүсэлт	3
3	Эрх бүхий албан тушаалтны өөрчлөх тухай	2
4	Хаягийн өөрчлөлт бүртгэх тухай	4



### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР:



Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд нийт **265** хүсэлт ирүүлснийг холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ. Үүнд:



#### Тусгай зөвшөөрөл:

1	ҮХЭХЗ-ын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай	3
---	---	---

#### Бүртгэл:

1	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	21
2	Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгэх тухай	47
3	Агентын өөрчлөлт бүртгэх тухай	137
4	Оноосон нэрийн өөрчлөлт	3
5	Салбар, төлөөлөгчийн газар нээх	1
6	Хаяг байршлын өөрчлөлт	22
7	Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч	2
8	Аудитын үйлчилгээ үзүүлэгч	10



### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАР:



Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд ирсэн **11** хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянаж, шийдвэрлэв. Үүнд:



1	ТУЗ-ийн гишүүний өөрчлөлтийг бүртгэх тухай	6
2	Комплайнсын ажилтны өөрчлөлтийг бүртгэх тухай	2
3	Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгэх тухай	3



### СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН:



Нийт **12** хүсэлт ирүүлснийг хянан шийдвэрлэсэн. Эдгээрийн **1** нь сэндбоксын орчинд орох шаардлагагүй үлдсэн **11** асуудлыг хянан шийдвэрлэсэн. Үүнд:



#### Бүтээгдэхүүн, үйлчилгээ турших:

1	Сэндбоксын зохицуулалтын орчинд орох тухай	1
2	Сэндбоксын зохицуулалтын орчинд турших хугацаа сунгах тухай	4
3	Сэндбокс орчноос шилжих тухай	3
4	Сэндбоксын орчноос гарах тухай	3



**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАР:**



Бүртгэл зөвшөөрлийн чиглэл **52** хүсэлт хүлээн авснаас **46** хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянаж, шийдвэрлүүлсэн болно. Үүнд:



1	МЗҮА эрхлэх этгээдээр бүртгэх тухай	<b>6</b>
2	Салбар бүртгэх тухай	<b>7</b>
3	Салбар хүчингүй болгох тухай	<b>3</b>
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд, бүрэлдэхүүн өөрчлөлт оруулах тухай	<b>9</b>
5	Хаяг байршлын өөрчлөлт бүртгэх тухай	<b>15</b>
6	Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгэх тухай	<b>2</b>
7	Оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэх тухай	<b>1</b>
8	МЗҮА эрхлэх этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох тухай	<b>2</b>
9	МЗҮА эрхлэх этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох тухай	<b>1</b>



# 06

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МӨНГӨ УГААХ  
ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТЭМЦЭХ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН  
ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

---





## ХЯНАЛТ ШАЛГАЛТ

### ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Санхүүгийн зохицуулах хороонд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, бусад шаардлага, шалгуурыг зайнаас хянаж, газар дээр нь хяналт, шалгалт гүйцэтгэх, зохицуулалттай

этгээдийн зохистой харьцаа алдагдаж, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хууль тогтоомж, журамд заасан албадлагын арга хэмжээ авах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.


**Зураг 29.** Газар дээрх бүрэн хэмжээний, хэсэгчилсэн хяналт шалгалт болон үзлэг шалгалтын тоо салбараар



## ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн улирал болон сарын тайлан, мэдээ, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга, дүрэм,

бүх гишүүдийн болон ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын баримт бичгийг хүлээн авч, зайнаас хянан шалгаж баталгаажуулан, холбогдох хариу, мэдэгдэл, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Үүнд:



## ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

**211**  
ШИЙТГЭЛ  
ОНОГДУУЛСАН  
ЗӨРЧИЛ

Шийтгэл оногдуулсан хэрэг	23
Шийтгэлээс чөлөөлсөн хэрэг	0
Хялбаршуулсан журмаар шалгасан	188
Газар дээр нь шийдвэрлэсэн	0

**211** ШИЙТГЭЛИЙН  
ТӨРӨЛ

Үндсэн – Торгох	23
Нэмэгдэл – Эрх хасах	0

### ТОРГУУЛИЙН МӨНГӨН ДҮН



**142**  
Хувь хүн



**108**  
Хуулийн  
этгээд

УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА



**205**

## МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛ

### СХН-ИЙН УДИРДЛАГЫН БАГТ ТОМИЛОГДЛОО



### ФАТФ– ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ХАРИЛЦАХ ГРУППЭД АЖИЛЛАЖ БАЙНА

ФАТФ–ын дэргэдэх Virtual Asset Contact Group (VACG)–д АНДМУТБ–ийн 42 улсыг төлөөлж ажиллахаар сонгогдлоо.

### “INTERNATIONAL CRYPTO AML SUPERVISOR’S ROUNDTABLE”–Д АЖИЛЛАЖ БАЙНА

**Австрали:** AUSTRAC  
**Канад:** FINTRAC  
**АНУ:** FINCEN  
**Их Британи:** FCA  
**Шинэ Зеланд:** FMA  
**Энэтхэг:** MOF  
**Дани:** FSA  
**Малайз:** SC  
**Тайланд:** AML Office  
**Япон:** FSA  
**Монгол Улс:** FRC

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН 2025 ОНЫ А/76 ДУГААР ТУШААЛ

Санхүүгийн зохицуулах хороо 10 модулийн хүрээнд 11 дэд ажлын хэсгүүдэд ахлагчаар болон ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж буй бөгөөд давхардсан тоогоор 169 төр, хувийн хэвшлийн төлөөллүүд тус үнэлгээнд ажиллаж байна.

### АХЛАН АЖИЛЛАЖ БҮЙ ДЭД АЖЛЫН ХЭСГҮҮД



### ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ДЭД АЖЛЫН ХЭСГҮҮД

**Модуль 4**

Үнэт цаасны салбар

**Модуль 5**

Даатгалын салбар

**Модуль 6.1**

ББСБ–ын салбар

**Модуль 6.1**

ХЗХ–ны салбар

**Модуль 6.3**

МЗҮАЭ–ийн салбар

**Модуль 9**

Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүн

**Модуль 11**

ВХҮҮ–ийн салбар

**Модуль 7**

ҮХЭХЗ–ын салбар

**Модуль 7**

ҮМҮЧЭТХЭАЭ–ийн салбар шсалбар

**Модуль 2**

Үндэсний эмзэг байдал

**Модуль 8**

Терроризмыг санхүүжүүлэх эрсдэл

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ



Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1–д заасан холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг мөн хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэх хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.



ХУУЛИЙН  
ХУГАЦААНД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭЖ  
АЖИЛЛАЛАА

НИЙТ 976

өргөдөл, гомдол хүлээн авч Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу хөтлөн бүртгэсэн.



670

АЛБАН  
БИЧГЭЭР



221


ЦАХИМ  
СИСТЕМЭЭР



85

11–11  
ТӨВӨӨР

### ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ САЛБАРААР АНГИЛЖ ҮЗВЭЛ:



Санхүүгийн зохицуулах хороо нийт 976 өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын 48.7 хувь нь даатгалын үйлчилгээтэй холбоотой байна.

Шийдвэрлэлтийн явц, авах арга хэмжээний онцлогоос шалтгаалан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй бөгөөд нийт шийдвэрлэлтийн дундаж хугацаа 21 хоног байна.

## ХЭРЭГ, МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ



Санхүүгийн зохицуулах хороо нь иргэний болон захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр татагдан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн бүрэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалан оролцож байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь **2025** онд өмнөх оны үлдэгдэл **13** хэрэг, шинээр **18** нэхэмжлэл хүлээн авч, **3** нэхэмжлэл шүүхэд гарган, нийт **34** хэрэг, маргаанд нэхэмжлэгч болон хариуцагчаар оролцож **120** гаруй удаагийн шүүх хуралдаанд оролцсон байна.

Санхүүгийн зохицуулах хороонд холбогдсон нэг хэрэг дунджаар **156** хоногт хянан шийдвэрлэгдэж байна.

### ЭРХ ЗҮЙН АНГИЛАЛ



Нийт хэрэг

**34**



Иргэний хэрэг

**3**  
8.8%



Захиргааны хэрэг

**31**  
91.2%

### ХЭРЭГ МАРГААНЫ АНГИЛАЛ /САЛБАРААР/

**47.1%**

**16 ХЭРЭГ**

Үнэт цаас



**14.7%**

**5 ХЭРЭГ**

Даатгал



**26.5%**

**9 ХЭРЭГ**

ББСБ



**8.8%**

**3 ХЭРЭГ**

ВХҮҮ, Мөнгөн



**2.9%**

**1 ХЭРЭГ**

Бусад



**19**

**ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭГДСЭН  
ХЭРЭГ**

Санхүүгийн зохицуулах  
хорооны талд шийдвэрлэсэн

**14 73.7%**

50:50 хувьтай шийдвэрлэсэн

**2 10.5%**

Хорооны эсрэг талд шийдвэрлэсэн

**3 15.8%**

07

ХАМТЫН АЖИЛЛАГАА,  
СУДАЛГАА, КОМПЛАЙНС,  
САНХҮҮ

---



## ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН OTC MARKETS GROUP БОЛОН КАНАДЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА

2025.04.29

OTC Markets Group болон Канадын Хөрөнгийн Бирж (CSE)-ийн удирдлагуудтай албан уулзалт хийлээ. Уулзалтаар тус байгууллагын платформоор дамжуулан хоёрдогч зах зээлийн арилжаа (cross-trading) хийх боломж, тавигдах шаардлагын талаар харилцан мэдээлэл солилцож, цаашид Монгол, АНУ-ын брокерын компаниудын дэд бүтцийн холболтыг хангах чиглэлээр хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тохиролцов.



### ҮНЭТ ЦААСНЫ ХОРООДЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛОО

2025.05.15

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын 50 дахь жилийн тайлангийн хуралд Катарын Доха хотноо оролцлоо.

Хурлаар дижиталчлал, кибер аюулгүй байдал, зах зээлийн тогтвортой байдал, крипто хөрөнгийн зохицуулалт, тогтвортой санхүүжилтийн асуудлыг хэлэлцэв. Санхүүгийн зохицуулах хороо нь IOSCO-ын Ази-Номхон далайн бүсийн хороо (APRC) болон Хөгжиж буй зах зээлийн хороо (GEMC)-ны гишүүн бөгөөд 2009 онд үндсэн гишүүнээр элссэн.



### “НОГООН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ХОЁРДУГААР ҮЕ ШАТЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

2025.06.05

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага, тогтвортой байдлыг бэхжүүлэх мөн байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг дэмжих замаар тогтвортой, ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн корпорац (OУСК)-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.



### БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН СӨҮЛИЙН БАТАЛГААНЫ ДААТГАЛЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАЛ СОЛИЛЦЛОО

2025.06.30

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун БНСУ-ын Сөүлийн баталгааны даатгалын газрын удирдлагуудтай уулзан, даатгагчийн баталгааны эрх зүйн орчин болон зах зээлийн өнөөгийн байдлын талаар санал солилцлоо. Уулзалтын үеэр даатгалын баталгааны зах зээлийг хөгжүүлэх, эрсдэлийн удирдлага болон мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг үргэлжлүүлэхээр тохиролцов.



## БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ДААТГАЛЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХАА ИЛЭРХИЙЛЛЭЭ

2025.08.20

Албан журмын даатгагчдын холбооны урилгаар БНСУ–ын Даатгалын хөгжлийн хүрээлэн (KIDI)–гийн гүйцэтгэх захирал Чанг–Еон Хё манай улсад ажлын айлчлал хийж, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун албан ёсоор хүлээн авч уулзлаа.

Айлчлалын үеэр Албан журмын даатгагчдын холбоо болон KIDI хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсныг онцолж, цаашид даатгалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, заавал даатгалын тогтолцоог хөгжүүлэх, боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцов.



## КАЗАХСТАН УЛСЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАТАЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

2025.09.04

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллага болох “Astana Financial Services Authority”–ын дарга Евгения Богданова нар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хил дамнансан санхүүгийн мэдээлэл солилцох, финтек болон виртуал хөрөнгийн чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов.



## ЯПОН, БНСУ–ЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООДЫН УДИРДЛАГУУДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

2025.09.16

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Т.Цэрэнбадрал Япон болон БНСУ–ын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдлагуудыг хүлээн авч уулзан, Монголын хөрөнгийн зах зээлийг таниулах, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр санал солилцлоо. Уулзалтын үеэр хоёр талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах талаар ярилцаж, цаашид дэмжин хамтран ажиллахаа илэрхийллээ.



## АЗИЙН ҮНЭТ ЦААСНЫ ФОРУМ УЛААНБААТАР ХОТНОО БОЛОВ

2025.12.16

“Азийн үнэт цаасны форум”–ын 30 дахь Ерөнхий чуулганыг Монгол Улсад 2025.09.11–ний өдөр зохион байгуулсан. Чуулганд Азийн 20 гаруй орны 24,000 гаруй гишүүн байгууллагыг төлөөлсөн төлөөлөгчид Улаанбаатар хотноо оролцож, бүс нутгийн хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагаа, тогтвортой хөгжил, дижитал шилжилт болон цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар санал солилцлоо.



## СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ



СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ  
жил бүр

Санхүүгийн зохицуулах хорооноос **2025** онд гүйцэтгэсэн судалгааны ажлуудаас **“Судалгааны товхимол 6”**–д түүвэрлэн нийтэлж, олон нийтийн хүртээл болголоо. Судалгааны үр дүн нь санхүүгийн салбарын бодлого боловсруулалт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой билээ.

Энэхүү товхимолд карбон зах зээлийн бүтэц, үйл ажиллагаа, санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ ба зохицуулалт, валют арилжих төвийн зохицуулалт ба олон улсын туршлага, санхүүгийн салбар дахь ногоон угаалтын зохицуулалт, үүсмэл санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын эрх зүйн орчин, гүн сургалтын арга ашиглан алтны үнийн богино хугацааны таамаглалын туршилт зэрэг **12** судалгааны ажил нийтлэгдлээ.

Судалгааны хүрээнд орчин үеийн санхүүгийн инноваци, зохицуулалтын шинэ чиг хандлага, ногоон хөгжил, салбарын тогтвортой байдлын асуудлыг Монгол Улсын санхүүгийн зах зээлтэй уялдуулан судалж, боломжит туршлагыг нэвтрүүлэх санал, зөвлөмж дэвшүүлсэнийг холбогдох журам, заавар болон эрх зүйн орчинд тусгах, мөн “судалгаанд тулгуурласан бодлого, зохицуулалтыг хөгжүүлэх”–д ашиглаж байна.

“Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”–ийн хүрээнд иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах, боломжийг хангах зорилгоор санхүүгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг тогтмол нийтэлж, цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна.



POWER BI ДАШБОАРД НЭВТРҮҮЛЭЭ  
улирал бүр



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ  
улирал бүр



ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ  
жил бүр



“САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ” СЭТГҮҮЛ  
сар бүр



“ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН  
МЭДЛЭГТ” ЦУВРАЛ ЗУРАГТ  
ХУУДАС  
сар бүр



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН  
7 ХОНОГИЙН МЭДЭЭ  
7 хоног бүр



СТАТИСТИК БЮЛЛЕТЕНЬ  
улирал бүр



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ  
сар бүр

Салбарын тойм, сэтгүүл, тоон мэдээлэл, судалгааны материалыг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn)) цахим шуудан ([rsa@frc.mn](mailto:rsa@frc.mn)) мөн **51-261106** утсаар холбогдон авах боломжтой.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС



Компанийн засаглалын тогтолцоо, комплайнсыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь аливаа компанийн урт хугацааны тогтвортой хөгжил цаашлаад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангагч суурь нөхцөл болдог. Санхүүгийн зохицуулах хороо энэ хүрээнд санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх ажлыг зохион байгуулж байна.



### КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, мөн УИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд “Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301”, “Нийгмийн хариуцлагын ISO 26000” стандартуудын үндсэн шаардлага, тэдгээрийг практикт нэвтрүүлэх асуудал, даатгалын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй сорилт, цаашдын чиг хандлагын талаар даатгагчийн эрх бүхий 30 албан тушаалтнуудыг хамруулан мэдээлэл өгч, санал солилцов. Мөн Авлигатай тэмцэх газар, Стандарчлал, хэмжил зүйн газартай хамтран тус стандартуудыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг олгох модуль сургалтыг зохион байгуулсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны газар болон хэлтсийн нийт 16 албан хаагч хамрагдсан байна.



### “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн баталснаар нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлэлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүрэгтэй болгосон.

2025 оны 2 дугаар улирлын байдлаар “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс хувьцаат компаниудын хувьд дунджаар 62.0 хувь буюу 5.4, даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ-ийн салбар дунджаар 75.3 хувь буюу 1.3 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус өссөн байна.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

1-р ангилал

2-р ангилал

3-р ангилал

МЭДЭЭЛЭЛ БҮРЭН  
БАЙРШУУЛСАН

82%

62%

ШИНЭЧЛЭЛТ  
ХИЙЖ БАЙГАА

7%

18%

МЭДЭЭЛЭЛ ДУТУУ  
БАЙРШУУЛСАН

18%

31%

50%

ЦАХИМ  
ХУУДСАГҮЙ

32%

### “КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ” НЭГДСЭН ТАЙЛАН

“Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 52 дугаар тушаалаар баталсан “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу зохицуулалттай дөрвөн салбар (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-т Комплайнсын эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэж нэгдсэн тайланг олон нийтэд ил тод мэдээлсэн.





## ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА.

Зөвшөөрлийн цахим системээр хуулийн этгээдийн бүртгэл болон зөвшөөрлийн хүсэлттэй холбоотой бичиг баримтыг хүлээн авч, нийт 120.0 гигабайт хэмжээтэй мэдээллийг бүрдүүлсэн. Мөн Фина системээр зохицуулалттай этгээдийн сар, улирлын

санхүүгийн тайлан, мэдээг хүлээн авах хүрээнд нийт 505.0 гигабайт хэмжээтэй мэдээллийг цуглуулж, системүүдийн хэвийн найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.

## КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ҮЕ ШАТТАЙГААР НЭМЭГДҮҮЛЖ, НУУЦЛАЛ ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАВ.

Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 158 тоот тушаалаар баталлаа.

Мөн мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, дараах арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- албан хаагчдын Оффис 365 болон компьютерын нэгдсэн эрхийн удирдлагыг хэрэгжүүлэх;

- нууц үгийн бодлогыг хэрэгжүүлж, хандах эрхийн давхар хамгаалалт (2FA)-ыг нэвтрүүлэх;
- галт ханын төхөөрөмж болон цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчлэх;
- хорт кодын эсрэг программ хангамжийг албан хаагчдын компьютерт суулгах;
- виртуал серверийн нөөцлөлт, хамгаалалтын программ хангамж нэвтрүүлж, тохируулах;
- цахим систем, вэбсайтын SSL хамгаалалтыг шинэчлэн тохируулах;
- сервер системийн нөөцлөлт хадгалалтыг тогтмол гүйцэтгэн, сар бүр үзлэг оношилгоо хийх.

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТУУДЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдын мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дараах 5 сэдвээр сургалт зохион байгуулсан. Үүнд:

- Зөвшөөрлийн цахим системийн ашиглалт;
- Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн аюулгүй байдлын бодлого;
- Кибер аюулгүй байдлыг хангах сургалт;
- Фина системийн шинэчлэлт, шинэ боломж;
- Албан хэрэг хөтлөлтийн цахим системийн ашиглалт.



## ТӨСӨВ, САНХҮҮ




2025 оны батлагдсан төсөв 20.9 тэрбум төгрөг байснаас урсгал зардал 20.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 0.2 тэрбум төгрөг байна. Гүйцэтгэл нь 18.4 тэрбум төгрөгт хүрч төсвийн биелэлт 90 хувьтай байна. Нийт санхүүжилтийн 75 хувийг улсын төсвийн санхүүжилтээр, 25 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлсэн.

Улсын төсөвт 4.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 4.7 тэрбум төгрөгт хүрч, биелэлт 116.7 хувьд хүрч давж биелсэн.



### ЗАРДЛЫН БҮТЦИЙГ ЗАДАЛЖ ХАРУУЛБАЛ:



- Цалин хөлс болон нэмэгдэл суутгал 76%
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 9%
- Нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 9%
- Засгийн газрын урсгал шилжүүлэг 2%
- Бусад зардал 4%

### ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг жигд, тасралтгүй, хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажиллалаа.

### ТӨСВИЙН САХИЛГА БАТ

Төлөвлөлтийг оновчтой хийж, төсвийг үр ашигтай зарцуулсан.

# 2026 ОНЫ ЗОРИЛТ



